


БАЙНГА ОРШИН СУУХ ЭРХ - ЧЕХ ХЭЛНИЙ ШАЛГАЛТ

Хэрэв та БНЧУ-д байнга оршин суух зөвшөөрөл хүсэх гэж байгаа бол чех хэлний шалгалтыг А2 түвшинд өгөх шаардлагатай.

- 2024 оны 1-р сарын 1-нээс эхэлж шалгалтын үнэ 3200 крон.
- Та [цахим өргөдлийн маягтаар](#).
- Бүртгэлийн үед та хүчинтэй паспорттой байх ёстой бөгөөд мөн шалгалтын өдөр шалгах болно.



Байнгын оршин суух эрхийн шалгалттай тэнцэх шалгалтууд нь:

- А2 болон түүнээс дээш түвшний ССЕ шалгалтууд (баталгаажсан шалгалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#))
 - улсын хэлний шалгалт эсвэл элсэлтийн шалгалт
 - иргэншил олгох зорилгоор чех хэлний шалгалт
- эмч, шүдний эмч, эм зүйч мэргэжлээр ажиллах мэргэжлийн ур чадвар олж авах, хүлээн зөвшөөрөх нөхцөлийг батлах шалгалт.



Чех хэлний А2 түвшний шалгалт нь аман болон бичгийн хэсгээс бүрдэнэ. Шалгалтын хоёр хэсэг нэг өдөр явагдана.

1. Шалгалтын бичгийн хэсэг нь хоёр хэсгээс бүрдэнэ:
 - a. Тест - Унших болон бичих, ойролцоогоор 65 минут (дараа нь завсарлана)
 - Тест – сонсох, ойролцоогоор 35-40 минут

Бичгийн шалгалтын хэсэгт шалгалт өгч буй хүн:

- тогтоосон завсарлагааны цагаас гадуур шалгалтын байрнаас гарч болохгүй,
- аливаа электрон төхөөрөмж, ном, толь бичиг ашиглах, авч явахыг хориглоно,
- бие даан ажиллана,
- шалгалтын шийдлийг зөвхөн хариултын хуудсан дээр бичнэ, үүний тулд шалгалтын байгууллагаас өгсөн бичгийн хэрэгслийг ашиглана,
- хариултын хуудас болон асуултын хуудсыг зохих цагт нь өгнө.

2. Шалгалтын аман хэсэг нь (ойролцоогоор 15 минут) дараах хэсгээс бүрдэнэ:
 - a. асуултуудад хариулна
 - b. үзүүлсэн зургийг үндэслэн даалгаврын хариуг шийдэх

Шалгалтыг амжилттай өгснийг нотлох баримт нь шалгалтын байгууллагаас олгосон гэрчилгээ юм. Шалгалтад унасан хүн дахин шалгалтад өгөхдөө хоёр хэсгийг дахин өгнө. Нэг хуанлийн жилд шалгалт өгч байгаа хүн, дээд тал нь гурван удаа шалгалт өгч болно.



Та дэлгэрэнгүй мэдээлэл болон туршилтын тестийг эндээс авах боломжтой
<https://cestina-pro-cizince.cz/trvaly-pobyt/a2/priprava-na-zkousku/>



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Poradna
pro integraci

Projekt "Centrum na podporu
integrace cizinců v Ústeckém kraji" reg.
č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je
financován OP AMIF a MV ČR.